ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА

ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

ТӨЛ-001
2 дахь хэвлэл

2022 он

Нэр	ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	ТӨЛ-001

БАТАЛГААЖУУЛАЛТЫН ХУУДАС

Энэхүү хуудас Гамшгаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний төлөвлөгөөний хамт хүчин төгөлдөр байна.

Байгууллага: Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба

ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Боловсруулсан	Хянасан	Батлсан
Албан тушаал: НУТА-НЫ ТСХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН	Албан тушаал: НУТА-НЫ ТСХ-ИЙН ДАРГА	Албан тушаал: НУТА-НЫ ДАРГА
Нэр: Б.ЭРДЭНЭТУЛГА	Нэр: Т.АЛТАНЗУЛ	Нэр: Т.БАТБАЯР
Гарын үсэг:	Гарын үсэг:	Гарын үсэг:
Огноо: 2022.10.04	Огноо: 2022-10-04	Огноо: 06.10.2022

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА
ХЭВЛЭГДСЭН ТОХИОЛДОЛД ХЯНАЛТГҮЙ ХУВЬ
2022 оны 10 сарын 06 өдөр

ИНЕГ НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА
ХЯНАЛТТАЙ ХУВЬ

БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТЫН МЭДЭЭЛЭЛ

Баримт бичгийн дэлгэрэнгүй *Document details*					
1	Баримт бичгийн нэр *Document name*		Гамшгаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний төлөвлөгөө		
2	Баримт бичгийн зорилго *Purpose of the Document*		Гамшгийн эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах зорилгоор албаны хэсгүүдийг нэгдсэн удирдлагаар хангахад оршино.		
3	Баримт бичгийн код *Unit Identification*		ТӨЛ:001		
4	Хуудасны тоо *Total page*		11		
5	Хэлбэр *Document Owner*		Хэвлэмэл-А4		
6	Хариуцах албан тушаалтан *Document Owner*		Технологи, судалгааны хэсгийн ахлах мэргэжилтэн		
7	Батлагдсан огноо *Date approved*		2022.10.06		
8	Баталсан байгууллага, албан тушаалтан *Approved by*		НУТА-ны дарга		
9	Өөрчлөлт, нэмэлт орсон байдал *Amendments*		2022.01.05 Анхны хувилбар 2022.10.06 Өөрчлөлт орсон		
10	Баримт бичгийн бүтэц *Document Structure*		8 бүлэг		
11	Хавсралт		4		
12	Тараагдсан байдал	Хэсэг, албан тушаалтан	Хяналтын дугаар	Хувь	Гарын үсэг
		Нислэгийн төлөвлөлт, зөвшөөрлийн хэсэг	01	Хяналттай хувь	
		Шуурхай төлөвлөлтийн хэсэг	02	Хяналттай хувь	
		Технологи, судалгааны хэсэг	03	Эх хувь	
		Захиргааны мэргэжилтэн	04	Хяналттай хувь	
		Дотоод хяналтын мэргэжилтэн	05	Хяналттай хувь	
		Нийт		5	

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА
ХЭВЛЭГДСЭН ТОХИОЛДОЛД ХЯНАЛТГҮЙ ХУВЬ
22.10.06

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА
ХЯНАЛТТАЙ ХУВЬ

ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

№	Өөрчлөлтийн дугаар	Өөрчлөлт батлагдсан огноо	Товч утга	Өөрчлөлт хийсэн шийдвэр	Өөрчлөлт хийсэн огноо
1		2022.01.05	Анхны хувилбар	Шинээр батлагдсан.	
2	1	2022.10.06	Шинэчлэн батлуулсан	Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2022 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн "Орон тоонд өөрчлөлт оруулах тухай" А/225 дугаар тушаалаар тус албаны менежерийн орон тоо хасагдсантай холбогдуулан шинэчлэн батлуулсан.	2022.10.04

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА
ХЭВЛЭГДСЭН ТОХИОЛДОЛД ХЯНАЛТГҮЙ ХУВЬ
22.10.06

Нэр	ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	ТӨЛ-001

ГАРЧИГ

Бүлэг	Агуулга	Хуудас
	Баталгаажуулалтын хуудас	
	Баримт бичгийн хяналтын мэдээлэл	i
	Өөрчлөлтийн бүртгэл	ii
	Гарчиг	iii
1	Нийтлэг үндэслэл	1
2	Хамрах хүрээ	1
3	Гамшгийн үеийн удирдлага, зохион байгуулалт	1-2
4	Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа	3
5	Нөөц, хангалт зохион байгуулалт	3
6	Гамшгийн нөхцөл байдал үүссэн үеийн үйл ажиллагаа	4
7	Гамшгаас хамгаалах үед албаны дарга, хэсгийн дарга, нислэгийн төлөвлөлт зөвшөөрлийн болон захиргааны мэргэжилтний хүлээх ерөнхий үүрэг хариуцлага	5
8	Бусад	6
9	Хавсралтууд	7-11

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА
ХЭВЛЭГДСЭН ТОХИОЛДОЛД ХЯНАЛТГҮЙ ХУВЬ
22.10.06

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Гамшгаас урьдчилан сэргийлэх (газар хөдлөлт, гал түймэр, үер гэх мэт) давагдашгүй хүчин зүйлсээс шалтгаалан онцгой байдал үүссэн үед Гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой комисс, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах зорилгоор албаны хэсгүүдийг нэгдсэн удирдлагаар хангахад оршино.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

2.1 Тус төлөвлөгөө нь гамшгийн байдал үүссэн үед албаны хэмжээнд мөрдөгдөнө.

ГУРАВ. ГАМШГИЙН ҮЕИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1 Үйл ажиллагаа

3.1.1 Гамшгийн үеийн бэлэн байдлын үед авах хариу арга хэмжээний мэдээ, мэдээллийг шуурхай солилцох, үнэн зөв, мэдээ мэдээллээр хангах үйл ажиллагааг зохион байгуулна.

3.1.2 Гамшгийн үеийн удирдлагыг дараах байдлаар зохион байгуулна.



3.1.3 Гамшгийн үед авах хариу арга хэмжээг уялдуулан зохицуулах, шуурхай зохион байгуулах, мэдээлэл дамжуулах, хүний нөөцийн нөөц төлөвлөгөөг оновчтой төлөвлөн гамшгаас хамгаалах өндержүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед ажиллана.

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА
ХЭВЛЭГДСЭН ТОХИОЛДОЛД ХЯНАЛТГҮЙ ХУВЬ
22 оны 10 сарын 06 өдөр

3.1.4 Гамшгийн үед албаны удирдлага, хэсгийн дарга нар, ахлах мэргэжилтэн, дотоод хяналтын болон захиргааны мэргэжилтэн байгын бэлэн байдалд байж, холбоо барих утсыг 24 цагийн турш нээлттэй байлган бэлэн байдлыг хангаж ажиллана.

3.1.5 Гамшгийн нөхцөл байдал үүссэн үед гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед ажиллах зааврыг мөрдлөг болгон нислэгийн урсгал төлөвлөлт, зөвшөөрлийн үйл ажиллагааг тасралтгүй явуулна.

3.1 Нөөц мэдээллийн сан

3.1.1 Нислэгийн урсгал төлөвлөлт, зөвшөөрлийн үйл ажиллагаанд ашиглах мэдээллийн санг НТЗХ, ШТХ-т цахим хэлбэрээр тогтмол үүсгэнэ.

3.2.2 Үүсгэсэн мэдээллийн санг зөөврийн хатуу дискэнд хадгалах ажлыг ТСХ хариуцах ба 7 хоног тутам шинэчилнэ.

3.3 Хүний нөөц

3.3.1 Гамшгийн үеийн нөхцөл байдал үүссэн үед хүний нөөцийн хомсдол үүсэхээс урьдчилан сэргийлж, албаны өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор хүний нөөцийн нөөц төлөвлөгөөтэй байх ба төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллана. /Хавсралт 2/

3.4 Нөөц ажлын байр

3.4.1 Албаны төв байр /НТЗХ, ТСХ/, ШТХ-ийн ажлын байр, тоног төхөөрөмж нь харилцан нөөц ажлын байр болно.

3.4.2 Нөөц ажлын байранд шилжин ажиллах ажилтны тухайн үеийн нөөц хангалтыг бүрдүүлж, бэлэн байдлыг ханган ажиллана.

4. Мэдээлэл дамжуулах

4.1 Гамшгийн үед авах хариу арга хэмжээний мэдээ, мэдээллийг, шуурхай солилцох, үнэн зөв, мэдээ, мэдээллээр шуурхай хангах үйл ажиллагааг албаны үйл ажиллагааны зааварт тусгагдсан дараах мэдээлэл дамжуулах схемийн дагуу зохион байгуулна.

ӨНДӨРЖҮҮЛСЭН БОЛОН БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ШИЛЖСЭН ҮЕД АЛБАНЫ МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ СХЕМ



НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА
ХЭВЛЭГДСЭН ТОХИОЛДОЛД ХЯНАЛТГҮЙ ХУВЬ
22 оны 06 дар

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА
ХЯНАЛТТАЙ ХУВЬ

ДӨРӨВ. ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.2 Гамшгийн нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, мэдлэг ойлголт өгөх, бэлэн байдлыг хангах, Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комисс, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр, мэргэжлийн байгууллага, засаг захиргааны нэгжээс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээллийг албаны ажилтнуудад шуурхай хүргэж удирдлагыг мэдээ, мэдээллээр хангахад чиглэнэ.

4.3 Гамшгийн нөхцөл байдал үүсэхээс сэргийлж холбогдох санамж, зөвлөмж, аюулгүйн гарцын мэдээллийг ажлын байруудад байршуулах, харилцаа холбоондоо гар утас, вайбэр групп, цахим хаягийг шууд ашиглан гар утасны бэлэн байдлыг 24 цагийн турш хангаж, цаг үеийн мэдээ, мэдээллийг тогтмол, давтамжтайгаар шуурхай хүргэн ажиллана.

ТАВ. НӨӨЦ, ХАНГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

5.1 Гамшгийн нөхцөл байдлын үед хангалтыг дараах байдлаар зохион байгуулах бөгөөд нөөц, хангалтыг нэн тэргүүнд бүрдүүлнэ.

№	Нөөц, хангалтын төрөл, бүрдүүлэлт	Хариуцах албан тушаалтан
1	Нэг удаагийн хамгаалах хэрэгсэл, халдваргүйжүүлэлт хийх бодисын хангалтын бэлэн байдал	ХАБЭА хариуцсан мэргэжилтэн
2	Хүний нөөцийн нөөц төлөвлөгөөний бэлэн байдал /Ажиллах хүчний хомсдол үүсэхээс сэргийлэн хүний нөөцийн нөөц төлөвлөлтийг хийх/	Захиргааны мэргэжилтэн, НТЗХ, ШТХ, ТСХ-ийн дарга нар
3	Ажилтнуудын ажлын байрны хүрэлцээг хангаж аюулгүй ажиллах нөхцлийг бүрдүүлнэ. /нэг өрөөнд байрлах хүний тоо, зай хэмжээг төлөвлөх/	Захиргааны мэргэжилтэн, Хэсгийн дарга нар
4	Нөөц ажлын байрны бэлэн байдал /нөөц ажлын байрны төлөвлөлтийг хийх/	Захиргааны мэргэжилтэн, Хэсгийн дарга нар
5	Харилцаа холбооны бэлэн байдал /Албаны ажилтнуудтай холбоо барих утасны дугаарын жагсаалтыг тогтмол шинэчлэх/	Захиргааны мэргэжилтэн
6	Тусгаарлах өрөөний бэлэн байдлыг хангах /халдварт өвчин илэрсэн үед тусгаарлах өрөөний төлөвлөлтийг хийх /	Захиргааны мэргэжилтэн
7	Ажлын хэрэгцээт файл, бусад шаардлагатай тоног төхөөрөмжийн бэлэн байдал /ажлын байрнаас авч, цахимаар ажиллах бэлэн байдлыг хангах/	Албаны өдрөөр ажиллах нийт бүрэлдэхүүн
8	Бичиг хэргийн (бичгийн цаас, принтерийн хор г.м) хэрэгслийн нөөц бүрдүүлэлтийн, бэлэн байдал	Захиргааны мэргэжилтэн, Хэсгийн дарга нар
9	Ундны усны нөөц бүрдүүлэлтийн бэлэн байдал	Захиргааны мэргэжилтэн, Хэсгийн дарга нар

ХЭВЛЭГДСЭН ТОХИОЛДОЛД ХЯНАЛТГҮЙ ХУВЬ
22.10.06

ЗУРГАА. ГАМШГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ ҮҮССЭН ҮЕИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

6.1 Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан Нислэгийн урсгал төлөвлөлт, зөвшөөрлийн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулахад чиглэн дараах журмыг мөрдлөг болгон ажиллана.

Түвшин	Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэг	Нислэгийн урсгал төлөвлөлт, зөвшөөрлийн үйл ажиллагаанд мөрдөх баримт бичиг
Шар	Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг	Өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед ажиллах журам
Улбар шар	Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг	

6.2 Гамшгийн нөхцөл байдал үүссэн тохиолдолд дараах баримт бичгийг мөрдөж ажиллана. Үүнд:

- Гамшгаас хамгаалах тухай Монгол Улсын хууль;
- Иргэний нисэхийн заналхийллийн үед авах арга хэмжээний нэгдсэн журам;
- Онцгой байдал үүссэн тухай мэдээлэл дамжуулах журам;
- "Чингис хаан" ОУНБ-ын ерөнхий зааврын 3-р бүлэг. Онцгой нөхцөлийн төлөвлөгөө;
- ИНЕГ-ын "Аюулгүй ажиллагааны мэдээлэл дамжуулах журам";
- АНҮГ-ын харьяа албадуудын агаарын навигацийн аюулгүй байдлын мэдээлэл дамжуулах, шуурхай ажиллагааны журам;
- НУТА-ны өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед ажиллах журам.

6.3 Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой комиссоос гаргасан тогтоол шийдвэр, тогтоосон хөл хорионд үндэслэн тухай бүр ИНЕГ, ИНҮТ-ийн даргын тушаал шийдвэрээр ажиллах ажлын тусгай горимыг тогтооно.

6.4 Гамшгийн нөхцөл байдал үүссэн үед Монгол Улсын Засгийн газраас тогтоосон төрийн байгууллагын үйл ажиллагааны тусгай горимыг мөрдлөг болгон ажлын байранд ажиллах болон зайнаас ажиллах хуваарийг батлуулж, зохион байгуулалтын холбогдох арга хэмжээг авч, нислэгийн урсгал төлөвлөлт, зөвшөөрлийн үйл ажиллагааг тасралтгүй явуулна.

6.5 Гамшгийн үед ээлжийн хуваарийн зохион байгуулалтыг нөхцөл байдалд тохируулан гамшгийн үеийн нөхцөл байдлын дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээ (Хавсралт 1)-ний дагуу зохион байгуулна.

6.6 Гамшгийн нөхцөл байдал үүссэн үед албаны төв байр /НТЗХ, ТСХ/, ШТХ-ийн ажлын байрыг харилцан нөөц ажлын байраар ашиглаж, шилжин ажиллах ба хүний нөөцийн хомсдол үүссэн, үүсэх нөхцөл байдал тулгарсан тохиолдолд албаны өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор албаны үйл ажиллагааны зааварт тусгагдсан хүний нөөцийн нөөц төлөвлөгөөний дагуу ажиллана. (Хавсралт 2)

6.7 Гамшгийн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан цахимаар ажиллах ажлын хэрэгцээт файл, бусад шаардлагатай тоног төхөөрөмжийг ажлын байрнаас авч, цахимаар ажиллах бэлэн байдлыг хангана.

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА
ХЭВЛЭГДСЭН ТОХИОЛДОЛД ХЯНАЛТГҮЙ ХУВЬ
22.10.06

ИНЕГ НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА
ХЯНАЛТГҮЙ ХУВЬ

6.8 Гамшгийн нөхцөл байдал үүссэн үед цахимаар ажиллах нөхцөл боломжийг бүрэн бүрдүүлж, ажилтнууд удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь гүйцэтгэн өдөр бүр ажлын явц, үр дүнг шууд харьяалагдах удирдлагад тайлагнаж ажиллана.

6.9 Уулзалт, хурал, семинарыг цахим хэлбэрээр зохион байгуулах, зайлшгүй шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагаас гаргасан зөвлөмжийн дагуу зохион байгуулна.

6.10 Гамшгийн нөхцөл байдал үүссэн үеийн бэлэн байдлыг хангах зорилгоор гар утсыг 24 цагийн турш нээлттэй байлган, цаг үеийн мэдээ, мэдээллийг тогтмол, давтамжтайгаар шуурхай хүргэнэ.

ДОЛОО. ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЕД АЛБАНЫ ДАРГА, ХЭСГИЙН ДАРГА, НИСЛЭГИЙН ТӨЛӨВЛӨЛТ ЗӨВШӨӨРЛИЙН БОЛОН ЗАХИРГААНЫ МЭРГЭЖИЛТНИЙ ХҮЛЭЭХ ЕРӨНХИЙ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

7.1 Албаны дарга:

Гамшгийн нөхцөл байдал үүссэн үед албаны үйл ажилаагааг тасралтгүй байхаар зохион байгуулж, ИНЕГ, ИНҮТ-ийн удирдлагуудыг нислэгийн мэдээллээр хангаж, гамшгийн үеийн хариу арга хэмжээний төлөвлөгөөний дагуу албаны үйл ажиллагааг зохион байгуулж удирдлагаар хангана.

7.3 Хэсгийн дарга нар:

Хэсгийн дарга нар нь хэсгийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах, мэргэжилтнүүдэд гамшгийн нөхцөл байдал үүссэн үед ажиллах зөвлөмж, ажлын байрны чиг үүргийг шуурхай өгч ажиллана.

- Гамшгийн нөхцөл байдал үүссэн үед ажиллах нислэгийн төлөвлөлт, зөвшөөрлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, үйл ажиллагааг тасралтгүй доголдолгүй явуулах удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллана. (НТЗХ, ШТХ-ийн дарга нар)
- Хэсгийн мэргэжилтнүүдийг гамшгийн үед ажиллах чиг үүрэг, удирдлага зохион байгуулалт, мэдээ мэдээллээр шуурхай хангаж, хэсгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана. (НТЗХ, ШТХ, ТСХ -ийн дарга нар)
- Албаны web site–д гамшгийн үед харилцах e-mail хаяг, утасны дугаарын мэдээллийг оруулах ажлыг зохион байгуулна. (ТСХ-ийн дарга)
- Гамшгийн нөхцөл байдал үүссэн үед ажиллах ажилтнуудын үйл ажиллагааг зохион байгуулж, гамшгийн үеийн мэдээ мэдээллийг албаны удирдлагад шуурхай мэдээлнэ. (НТЗХ, ШТХ, ТСХ -ийн дарга нар)

7.4 Нислэгийн төлөвлөлт, зөвшөөрлийн мэргэжилтэн (24 цаг):

Нислэгийн төлөвлөлт, зөвшөөрлийн мэргэжилтэн нь ээлжийн зохион байгуулалтаар ажиллана.

- Нислэгийн урсгал төлөвлөлт, зөвшөөрлийн үйл ажиллагааг тасралтгүй явуулна.
- Гамшгийн үеийн мэдээ мэдээллийг 71-281602 дугаарын утсаар хуваарийн дагуу ИНЕГ, ИНҮТ-ийн Шуурхай штаб, албаны удирдлагад цаг тухайд нь шуурхай мэдээлнэ.

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА
ХЭВЛЭГДСЭН ТОХИОЛДОЛД ХЯНАЛТГҮЙ ХУВЬ
2022 он 10 сар 06 өдөр

ИНЕГ НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА
ХЯНАЛТТАЙ ХУВЬ

7.5 Захиргааны мэргэжилтэн:
Гамшгийн үед нислэгийн урсгал төлөвлөлт, зөвшөөрлийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахад шаардагдах, нөөц ажлын байранд шилжин ажиллах үеийн нөөц хангалтыг тооцож, урьдчилан бүрдүүлэх ажлыг хариуцаж ажиллах ба албаны ажилтнуудын гэрийн хаяг утасны жагсаалтад өөрчлөлт орсон тохиолдолд тогтмол шинэчилж, хэсгүүдэд хүргүүлэх ажлыг зохион байгуулна.

8. БУСАД

8.1 Гамшгийн үеийн төлөвлөлтийн дагуу нисэх буудалд код (Хавсралт 5) зарлагдсан тохиолдолд энэхүү төлөвлөгөө хамаарахгүй бөгөөд "Чингис хаан" ОУНБ-ын агаарын хөлгийн осол зөрчил гарсан тохиолдолд ИНД-12-ийн дагуу Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллагад нэн даруй мэдээлнэ.

9. ХАВСРАЛТУУД

1	Хавсралт 1	Гамшгийн үед ажиллах шуурхай төлөвлөлтийн хэсгийн ээлжийн бүрэлдэхүүний зохион байгуулалт
2	Хавсралт 2	Хүний нөөцийн нөөц төлөвлөгөө
3	Хавсралт 3	Аюулгүйн гарцын схем
4	Хавсралт 4	Гамшиг буюу онцгой байдлын ангилал, зарлан мэдээлэх код

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА
ХЭВЛЭГДСЭН ТОХИОЛДОЛД ХЯНАЛТГҮЙ ХУВЬ
2022 оны 06 сарын өдөр

ИНЕГ
НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА
ХЯНАЛТТАЙ ХУВЬ

Нэр	ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	ТӨЛ-001

Хавсралт 1

Гамшгийн үед ажиллах Шуурхай төлөвлөлтийн хэсгийн ээлжийн бүрэлдэхүүний зохион байгуулалт

Хувилбар 1

№	Гамшгийн үе шат	НТМ / НБГО			
		Ээлжийн тоо	Нэг ээлжинд ажиллах хүний тоо	Ажиллах цаг	Нөөц ээлжийн тоо
1	Гамшгийн үе /систем дотор гамшгаас хамгаалах бэлэн байдал зарлагдсан үе /	5	2	12/12	2
2	Гамшгийн үе II phase /ээлжийн бүрэлдэхүүнд халдвар илэрсэн/	4	2	12/12	2
3	Гамшгийн үе I phase /ээлжийн бүрэлдэхүүний нөөц хангалтгүй/	4	2	12/12	1
4	Гамшгийн үе 0 phase /ээлжийн зохион байгуулалт хийх боломжгүй/	3	2	24	0

Хувилбар 2

№	Гамшгийн үе шат	НТМ / НБГО			
		Ээлжийн тоо	Нэг ээлжинд ажиллах хүний тоо	Ажиллах цаг	Нөөц ээлжийн тоо
1	Гамшгийн үе /систем дотор гамшгаас хамгаалах бэлэн байдал зарлагдсан үе /	3	2	24	6
2	Гамшгийн үе II phase /ээлжийн бүрэлдэхүүнд халдвар илэрсэн/	3	2	24	5
3	Гамшгийн үе I phase /ээлжийн бүрэлдэхүүний нөөц хангалтгүй/	3	2	24	3
4	Гамшгийн үе 0 phase /ээлжийн зохион байгуулалт хийх боломжгүй/	3	2	24	1

Хувилбар 3

№	Гамшгийн үе шат	НТМ / НБГО			
		Ээлжийн тоо	Нэг ээлжинд ажиллах хүний тоо	Ажиллах цаг	Нөөц ээлжийн тоо
1	Гамшгийн үе /систем дотор гамшгаас хамгаалах бэлэн байдал зарлагдсан үе /	3	2	24	6
2	Гамшгийн үе II phase /ээлжийн бүрэлдэхүүнд халдвар илэрсэн/	3	2	24	3
3	Гамшгийн үе I phase /ээлжийн бүрэлдэхүүний нөөц хангалтгүй/	3	2	24	1
4	Гамшгийн үе 0 phase /ээлжийн зохион байгуулалт хийх боломжгүй/	3	2	24	0

ГАМШГИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА
ХЭВЛЭГДСЭН ТОХИОЛДОЛД ХЯНАЛТГҮЙ ХУВЬ
22.10.06
ГАМШГИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА
ХЯНАЛТТАЙ ХУВЬ

Хавсралт 2

ХҮНИЙ НӨӨЦИЙН НӨӨЦ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Албан тушаал	Орон тоо	Ажлын цаг	Орлох албан тушаалтан	Орлох орон тоо
1	Нислэгийн төлөвлөлт, зөвшөөрлийн хэсгийн дарга	1	8 цаг	Шуурхай төлөвлөлтийн хэсгийн дарга	1
2	Шуурхай төлөвлөлтийн хэсгийн дарга	1	8 цаг	Нислэгийн төлөвлөлт, зөвшөөрлийн хэсгийн дарга	1
3	Технологи, судалгааны хэсгийн дарга	1	8 цаг	Технологи, судалгааны хэсгийн ахлах мэргэжилтэн	1
4	Нислэгийн урсгал төлөвлөлтийн мэргэжилтэн	4	8 цаг	Нислэгийн урсгал төлөвлөлтийн мэргэжилтэн	1
				Нислэгийн төлөвлөлтийн мэргэжилтэн	1
5	Технологи, судалгааны хэсгийн ахлах мэргэжилтэн	1	8 цаг	Автоматжуулалт, сүлжээний мэргэжилтэн	1
				Судалгааны мэргэжилтэн	
6	Судалгааны мэргэжилтэн	1	8 цаг	Технологи, судалгааны мэргэжилтэн	1
				Мэргэжилтэн	1
7	Технологи, судалгааны мэргэжилтэн	2	8 цаг	Технологи, судалгааны мэргэжилтэн (хамтын ажиллагаа)	1
				Технологи, судалгааны мэргэжилтэн	1
8	Технологи, судалгааны мэргэжилтэн (хамтын ажиллагаа)	1	8 цаг	Технологи, судалгааны мэргэжилтэн	1
				Мэргэжилтэн	1
9	Автоматжуулалт, сүлжээний мэргэжилтэн	1	8 цаг	Технологи, судалгааны мэргэжилтэн	1
10	Мэргэжилтэн	1	8 цаг	Технологи, судалгааны мэргэжилтэн (хамтын ажиллагаа)	1
				Судалгааны мэргэжилтэн	1
11	Нислэгийн төлөвлөлтийн мэргэжилтэн	2	8 цаг	Нислэгийн төлөвлөлтийн мэргэжилтэн	1
				Нислэгийн урсгал төлөвлөлтийн мэргэжилтэн	1
12	Нислэгийн төлөвлөлтийн мэргэжилтэн	5	24 цаг/5,4, 3 ээлж	Нислэгийн төлөвлөлтийн мэргэжилтэн/ өдөр	1
				Нислэгийн урсгал төлөвлөлтийн мэргэжилтэн	1
13	Нислэгийн бүртгэл, гүйцэтгэлийн оператор	6	24 цаг/5,4, 3 ээлж	Нислэгийн бүртгэл, гүйцэтгэлийн оператор	1
14	Дотоод хяналтын мэргэжилтэн	2	8 цаг	Дотоод хяналтын мэргэжилтэн	1
15	Захиргааны мэргэжилтэн	1	8 цаг	Технологи, судалгааны мэргэжилтэн	1
				Мэргэжилтэн	1
16	Агаарын зайн мэргэжилтэн	1	8 цаг	Дотоод хяналтын мэргэжилтэн	1

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА
ХЭВЛЭГДСЭН ТОХИОЛДОЛД ХЯНАЛТГҮЙ ХУВЬ
22.10.06

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА
ХЯНАЛТТАЙ ХУВЬ

Хавсралт 3

Аюулгүйн гарцын схем



Хэвлэлтийн дугаар: 2/2022.10.04
Хяналтын дугаар: 04
Нэмэлт өөрчлөлтийн дугаар: 1

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА
ХЭВЛЭГДСЭН ТОХИОЛДОЛД ХЯНАЛТГҮЙ ХУВЬ
22/10/06

ИНЕГ НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТ АЛБА
ХЯНАЛТТАЙ ХУВ

Аюулгүйн гарцын схем



НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА
ХЭВЛЭГДСЭН ТОХИОЛДОЛД ХЯНАЛТГҮЙ ХУВЬ
2022.10.06 сар өдөр

ИНЕГ
НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА
ХЯНАЛТТАЙ ХУВЬ

Хавсралт 4

ГАМШИГ БУЮУ ОНЦГОЙ БАЙДЛЫН АНГИЛАЛ,
ЗАРЛАН МЭДЭЭЛЭХ КОД

КОД 1 - НИСЭХ БУУДАЛ ДАХЬ АГААРЫН ХӨЛГИЙН СҮЙРЭЛ
Нисэх буудлын периметрийн хашааны доторх агаарын хөлгийн сүйрэл.

КОД 2 - НИСЭХ БУУДЛЫН ГАДНА БОЛСОН АГААРЫН ХӨЛГИЙН СҮЙРЭЛ
Нисэх буудлын периметрийн хашааны гадна, гэхдээ нисэх буудлын газар зүйн байрлалын төвөөс эргэн тойронд 8 километрийн дотор гарсан агаарын хөлгийн сүйрэл.

КОД 3 - НИСЛЭГИЙН ҮЕИЙН ОНЦГОЙ БАЙДАЛ
Нисэх буудалд ойртон ирж буй агаарын хөлгийн багийнхан ямар нэгэн онцгой байдал гарсан тухай, эсвэл сүйрэлд хүргэж болзошгүй хүндрэл гарсан тухай мэдэгдсэн тохиолдол.

КОД 4 - БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ГАЛ (агаарын хөлөгт бус)
Барилга байгууламж, тоног төхөөрөмж, машин техникт гал түймэр гарсан тохиолдол. Энд агаарын хөлгийн гал хамаарахгүй.

КОД 5 - ШАТАХУУН АСГАХ БА АЮУЛТАЙ АЧАА
Шатахуун, шатах тослох материал асгаж гал түймэр гаргах, дэлбэрэлт болох эсвэл аюултай ачаа хаяж байгаль орчныг бохирдуулах явдал.

КОД 6 - ТЭСРЭХ БӨМБӨГӨӨР АГААРЫН ХӨЛГИЙГ ЗАНАЛХИЙЛЭХ
Газарт байгаа эсвэл нисэж буй агаарын хөлөгт тэсрэх бөмбөг тавьсан тухай мэдээлэл (сэжиг , таамаглал) авсан тохиолдол.

КОД 7 - БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ ТЭСРЭХ БӨМБӨГӨӨР ЗАНАЛХИЙЛЭХ
Нисэх буудлын барилга байгууламжид эсвэл түүний ойролцоо тэсрэх хэрэгсэл тавьсан тухай мэдээлэл (сэжиг, таамаглал) авсан тохиолдол.

КОД 8 - АГААРЫН ХӨЛГИЙГ БУЛААН АВАХ
Агаарын хөлгийг хүч хэрэглэн хууль бусаар булаан эзлэх эсвэл хяналтандаа авах тохиолдол. Үүнд хүч хэрэглэхээр заналхийлэх болон бүх төрлийн айлган сүрдүүлэх үйл ажиллагаа орно.

КОД 9 - ЭРҮҮЛ МЭНДИЙН ОНЦГОЙ БАЙДАЛ
Нислэг-техникийн хэргийн уршгаар эрүүл мэндээр хохирсон хүмүүст нэн яаралтай эмнэлэгийн анхны тусламж үзүүлэх, эсвэл тэдгээрийн амийг аврах, эсвэл гэмтэж бэртсэн хүмүүсийг эмнэлэг рүү тээвэрлэн зөөх тохиолдол.

КОД 10 - БАЙГАЛИЙН ГАМШИГ
Энэ төлөвлөгөөнд тодорхойлсноос бусад байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол. Эдгээрт байшин нурах, хүчтэй шуурга үүсэх, газар хөдлөх, гол,мөрөн үерлэх болон бусад үзэгдлүүд багтана.

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА
ХЭВЛЭГДСЭН ТОХИОЛДОЛД ХЯНАЛТГҮЙ ХУВЬ
22 он 10 сар 06 өдөр

ИНЕГ НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА
ХЯНАЛТТАЙ ХУВЬ